



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"Тохилог хараа" ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/11-НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn</p> <p>Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум</p> <p>2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа</p> <p>Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Батмөнх</p> <p>Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Наранцэцэг</p> <p>Утас: 70363047 Цахим хаяг: Narantsetsegba@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

Агуулга

1. Төрийн аудитын санал, дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5-9
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	12
4. Аудитын тайлан	13
4.1. Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.3.1 Шилэн дансны мэдээлэл	14
4.3.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.3.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	15
4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.4.1 Завсрын аудитын талаар.....	15
4.4.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	15
4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. Аудитын илрүүлэлт.....	16-18
5.1 Залруулга	16
5.2 Албан шаардлага.....	16
5.3 Зөвлөмж	17-18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	18-20



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2024.03.15 № 01А-2024/11-НА-СТ-ОНН

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Тохилог хараа” ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчлийн нөлөөг эс тооцвол “Тохилог хараа” ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн ИТХ-ын 2023 оны 107 дугаар тогтоолоор “Мандал энерго” ОНӨААТҮГ-аас тус үйлдвэрийн газарт нийт 186,743.8 мянган төгрөгийн хөрөнгийг балансасан балансад, сумын ОНХС-аар хийгдсэн 66,778.6 мянган төгрөгийн хогийн цэгийн хашаа, 85,504.1 мянган төгрөгийн гэрэлтүүлгийг тус тус үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэл, тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

“Тохилог хараа” ААТҮГ-ын 2023 оны нийт зардлын төлөвлөгөөнд үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцож төлөвлөөгүйгээс гүйцэтгэлээр зардлын төлөвлөгөөг 3.6 дахин хэтрүүлсэн байдалтай тайлагнагдсан байна.

018020930

Бусад асуудлын хэсэг

“Тохилог хараа” ААТҮГ-ын 2023 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 14 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжүүлснийг Мандал сумын ИТХ-ын 2024 оны 133 дугаар тогтоолоор үйл ажиллагааны тайланг “Хангалттай” дүгнэсэн байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1.	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө	6,937,788.18	31,604,774.86
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,870,388.18	67,210.06
1.1.2	Дансны авлага	0.00	6,444,160.00
1.1.3	Бараа материал	3,067,400.00	25,093,404.80
	Эргэлтийн хөрөнгийн дүн	6,937,788.18	31,604,774.86
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	21,798,345,784.06	19,656,619,819.81
1.2.1	Үндсэн хөрөнгө	20,784,107,586.39	18,637,035,622.14
1.2.2	Биет бус хөрөнгө	1,014,238,197.67	1,019,584,197.67
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	21,798,345,784.06	19,656,619,819.81
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	21,805,283,572.24	19,688,224,594.67
2.	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	56,157,344.47	33,598,042.38
2.1.1.1	Дансны өглөг	51,640,644.81	14,676,693.00
2.1.1.2	Цалингийн өглөг	820,900.00	735,231.78
2.1.1.3	Татварын өр	3,527,500.00	18,186,117.60
2.1.1.4	НДШ-ийн өглөг	168,299.66	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	56,157,344.47	33,598,042.38
2.2	Өр төлбөрийн нийт дүн	56,157,344.47	33,598,042.38
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	1,014,238,197.67	1,014,238,197.67
2.3.2	Эздийн өмчийн бусад хэсэг	0.00	339,026,481.01
2.3.3	Хуримтлагдсан ашиг	20,733,340,183.22	18,299,814,026.73
2.3.4	Тайлант үеийн хуримтлагдсан ашиг	-1,722,210,003.07	-2,455,336,098.47
2.3.5	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,547,846.88	1,547,846.88
2.3.6	Эздийн өмчийн дүн	21,749,126,227.77	19,654,626,552.29
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	21,805,283,572.24	19,688,224,594.67

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мерийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	688,461,002.96	922,213,111.00
2	Борлуулалтын өртөг	329,527,654.93	653,523,112.56
3	Нийт ашиг (алдагдал)	358,933,348.03	268,689,998.44
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	767,625,173.48	
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	411,498,948.35	231,041,169.13
11	Санхүүгийн зардал		
12	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,437,269,576.23	2,493,216,186.53
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-231,258.73
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-1,722,210,003.07	-2,455,336,098.49
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-1,722,210,003.07	-2,455,336,098.49
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-1,722,210,003.07	-2,455,336,098.49
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	-1,722,210,003.07	-2,455,336,098.49
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,014,238,197.67	1,547,846.88	22,455,550,186.29	23,471,336,230.84
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,014,238,197.67	1,547,846.88	22,455,550,186.29	23,471,336,230.84
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
Тайлант үеийн үр дүн			-1,722,210,003.07	-1,722,210,003.07
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,014,238,197.67	1,547,846.88	20,733,340,183.22	21,749,126,227.77
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,014,238,197.67	1,547,846.88	20,733,340,183.22	21,749,126,227.77
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			21,809,942.00	21,809,942.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,014,238,197.67	1,547,846.88	20,755,150,125.22	21,770,936,169.77
Өмчид гарсан өөрчлөлт	339,026,481.01			339,026,481.01
Тайлант үеийн үр дүн			-2,455,336,098.49	-2,455,336,098.49
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,353,264,678.68	1,547,846.88	18,299,814,026.73	19,654,626,552.29

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	688,461,002.96	1,070,199,311.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)		
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	94,280,202.96	147,986,200.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	594,180,800.00	826,901,400.00
1.1.6	Бусад мөнгөн орлого		95,311,711.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	683,259,241.93	1,061,307,489.12
1.2.1	Ажиллагчдад төлсөн	356,670,324.14	416,707,302.03
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	44,620,174.67	128,722,513.36
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	94,332,315.20	72,580,910.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	74,497,503.72	145,037,335.35
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	98,939,005.00	122,491,989.20
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,270,070.00	19,213,931.13
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	891,101.10	1,158,910.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	12,038,748.10	155,394,598.05
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,201,761.03	8,891,821.88
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,400,000.00	12,695,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,400,000.00	6,755,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		5,940,000.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,400,000.00	12,695,000.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-198,238.97	-3,803,178.12
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,068,627.15	3,870,388.18
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,870,388.18	67,210.06

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт орлого	м/төг	949,328.7	922,213.1	27,115.6	97.1
	Хог үүсгэвэр, хог тээврийн төвлөрүүлэх орлого	м/төг	150,000.0	150,452.3	-452.3	100.3
	Татаас санхүүжилтийн орлого	м/төг	676,000.0	676,449.1	-449.1	100.1
	Бусад орлого	м/төг	31,651.0	35,175.3	-3,524.3	111.1
	Туслах үйл ажиллагааны орлого	м/төг	91,677.7	60,136.4	31,541.3	65.6
2	Нийт зарлагын дүн	м/төг	949,328.7	3,377,780.5	2,428,451.8	
	Цалингийн зардал	м/төг	515,986.4	504,397.6	11,588.8	97.8
	НДШ-ийн зардал	м/төг	74,820.7	72,541.2	2,279.5	97.0
	Цэвэр усны зардал	м/төг	190.0	227.0	-37.0	119.5
	Цахилгааны зардал	м/төг	84,655.0	95,751.4	-11,096.4	113.1
	Дулааны зардал	м/төг	20,582.7	14,009.9	6,572.8	68.1
	Түлш, шатахууны зардал	м/төг	112,405.4	122,344.2	-9,938.8	108.8
	Урсгал засварын зардал	м/төг	36,766.0	22,467.4	14,298.6	61.1
	Бичиг хэргийн зардал	м/төг	3,612.0	1,406.1	2,205.9	38.9
	Албан томилолтын зардал	м/төг	781.0	0.0	781.0	0.0
	Нормын хувцасны зардал	м/төг	4,100.0	1,171.0	2,929.0	28.6
	Сэлбэг хэрэгсэл	м/төг	35,000.0	29,994.5	5,005.5	85.7
	Цэвэрлэгээ, ариутгалын зардал	м/төг	1,720.0	1,107.4	612.6	64.4
	Шуудан холбооны зардал	м/төг	1,210.8	740.8	470.0	61.2
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс	м/төг	2,981.6	0.0	2,981.6	0.0
	Албан татвар, даатгалын зардал	м/төг	3,173.0	584.0	2,589.0	18.4
	Нэг удаагийн тэтгэмж	м/төг	8,000.0	0.0	8,000.0	0.0
	Бусад зардал /өглөг/	м/төг	33,404.1	4,895.5	28,508.6	14.7
	Хөрөнгө оруулалт	м/төг	9,940.0	12,695.0	-2,755.0	127.7
3	Үндсэн хөрөнгийн элэгдэл	м/төг	0.00	2,493,216.2	-2,493,216.2	
4	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	м/төг	0.00	231.3	-231.3	
5	Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	м/төг	0.00		0.00	
9	Орлогын албан татвар	м/төг	0.00		0.00	
7	Татварын дараах ашиг, алдагдал	м/төг	0.00		0.00	

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Тохилог хараа” ААТҮГ нь *Ицаашид Тохилог хараа ААТҮГ гэх! “Мандал сумын иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, ажиллах нөхцөлийг хангаж, өнгө төрхийг орчин үеийн хөгжлийн шинэ түвшинд хүргэх, ногоон байгууламжаа нэмэгдүүлж, байгальд ээлтэй иргэдтэй, хог хаягдлаа ангилдаг ногоон сум болгох”* гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

“Тохилог хараа” ААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбай, авто замын хог хаягдлыг цэвэрлэх, ачиж тээвэрлэх,
- Сумын төвийн ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг зөөж тээвэрлэх,
- Сумын төвийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн үйл ажиллагаа,
- Сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайн тохижилт үйлчилгээ,
- Авто зам болон нийтийн эдэлбэр газрын гэрэлтүүлгийн ашиглалт, засвар үйлчилгээ,
- Гадаад, дотоод худалдаа эрхлэх,
- Авто тээвэр, бусад төрлийн машин механизмаар төлбөртэй үйлчлэх,
- Өөрийн эзэмшлийн хөрөнгө болон ажил үйлчилгээг бусдад түрээсээр ашиглуулах гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Мандал сумын ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор “Тохилог хараа” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулсан бөгөөд 2021 оноос улсын бүртгэлийн гэрчилгээ, тамга, тэмдгийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болгон өөрчилсөн байна.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын ж-д “Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-т “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай тус тус нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон гэх мэт.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Тохилог хараа” ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

“Тохилог хараа” ААТҮГ нь аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Тохилог хараа” ААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,117,059.0 мянган төгрөгөөр буюу 9.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,870.4	67.2	(3,803.2)
Авлага	0.0	6,444.2	6,444.2
Бараа материал	3,067.4	25,093.4	22,026.0
Үндсэн хөрөнгө	21,798,345.8	19,656,619.8	(2,141,726.0)
Нийт хөрөнгийн дүн	21,805,283.6	19,688,224.6	(2,117,059.0)
Өр төлбөр	56,157.4	33,598.0	(22,559.4)
Эздийн өмч	21,749,126.2	19,654,626.6	(2,094,499.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	21,805,283.6	19,688,224.6	(2,117,059.0)

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данс байна.
Үүнд:

- Дансны авлага 6,444.2 мянган төгрөг болж нэмэгдсэн нь хог тээврийн төлбөрийн авлага өссөнөөс шалтгаалсан байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 25,093.4 мянган төгрөг болж 22,026.0 мянган төгрөгөөр өссөн нь 214 ширхэг гэрлийн толгой худалдан авч үлдэгдлээр тайлагнагдсантай холбоотой байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 19,656,619.8 мянган төгрөг болж 2,141,726.0 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал өссөнөөс голлон шалтгаалсан байна.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 33,598.0 мянган төгрөг болж 22,559.4 мянган төгрөгөөр буурсан нь дулааны өр төлбөрийг барагдуулж, татварын өр төлбөрийн үлдэгдэлтэй тайлагнагдсанаас голлон шалтгаалжээ.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Тохилог хараа” ААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Мандал сумын ИТХ-ын 2023 оны 94 дүгээр тогтоолоор “Тохилог хараа” ААТҮГ-ын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 919,328.7 мянган төгрөгөөр, нийт зардлыг 909,388.7 мянган төгрөгөөр /үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцож, төлөвлөөгүй/ тогтоож, хөрөнгө оруулалтын 2 арга хэмжээнд нийт 9,940.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 111 дүгээр тогтоолоор татаас санхүүжилтийн орлого болон урсгал зардлыг тус тус 30,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 922,213.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 3,377,780.5 мянган төгрөгийн зардал гарган, 2,455,567.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан гэж тайлагнасан байна.

Нийт орлогын төлөвлөгөө 27,115.6 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар тасарсан нь тоног төхөөрөмжийн түрээсийн орлогын төлөвлөгөө /Тус үйлдвэрийн газрын эзэмшилд бүртгэгдсэн автогридер, зам индүүлэх хусагч индүү зэрэг техник хэрэгслийг бусдад түрээсэлж түрээсийн орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн байсан. Гэвч Мандал сумын Засаг даргын 2023 оны 01/610 дугаар албан бичгээр дээрх хөрөнгүүдийг “Мандал энерго” ОНӨААТҮГ-т шилжүүлэн тухайн техник хэрэгслийг авч явснаас төлөвлөсөн түрээсийн орлого бүрдээгүй байна/ тасарснаас голлон шалтгаалсан байна.

Нийт зардлын төлөвлөгөөнд үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал /2023 оны үндсэн хөрөнгийн элэгдэл 2,493,216.2 мянган төгрөг/-ыг тооцож төлөвлөөгүйгээс нийт зардал 3,377,780.5 мянган төгрөгийн /төлөвлөөгүй хөрөнгийн элэгдлийн зардлыг

хасаж тооцвол 884.564.3 мянган төгрөг буюу төлөвлөсөн зардлыг 2.7 хувь хэмнэсэн/ гүйцэтгэлтэй тайлагнагдан, төлөвлөсөн зардал 3.6 дахин хэтэрсэн харагдаж байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. Аудитын тайлан

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Тохилог хараа” ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн орлого зарлагын төлөвлөлт, үндсэн хөрөнгө болон мөнгөн касстай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Тохилог хараа” ААТҮГ нь 2023 оны санхүүгийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 50 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 3,178,296.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **31,782.9** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

“Тохилог хараа” ААТҮГ нь тайлант хугацаанд шилэн дансанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 127 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 24 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Үүнд:

- *Зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт – 1, 2, 8, 9, 10 дугаар сард,*
- *Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан – 7 дугаар сард тус тус хоцроосон бол,*
- *Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг-1-12 дугаар сар,*
- *Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт - 1-12 дугаар сарын мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.3.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Тохилог хараа” ААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Түлш, халаалтын зардлыг 6,572.8 мянган төгрөгөөр,*
- *Бичиг хэргийн зардлыг 2,361.5 мянган төгрөгөөр,*
- *Сэлбэгийн зардлыг 5,005.5 мянган төгрөгөөр,*
- *Нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 8,000.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэн,*
- *Хандив тусламжийн шинжтэй зардал гаргаагүй,*
- *Өөрийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан аваагүй гэх мэт.*

4.3.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

“Тохилог хараа” ААТҮГ нь харьцуулалтын аргын босго үнээс давсан 123,840.9 мянган төгрөгийн түлш, шатахууны худалдан авалтыг нээлттэй тендер

шалгаруулалтын аргаар бус Шунхлай петролиум, Тэс петролиум, Сод монгол зэрэг компаниудтай шууд гэрээ байгуулж, гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална", 8 дугаар зүйлийн 8.4-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгоходоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ"-ийн 1: "Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-70.0 сая төгрөг" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах зөвлөмж хүргүүлэв.

4.4. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.4.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 124 дүгээр "Санхүүгийн тайланд аудит хийх тухай" албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 03 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

4.4.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг аудитаар дахин хянахад 66.7 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,495.0	1	1,495.0	100.0
Албан шаардлага	1				0.0
Зөвлөмж	3	33,490.0	3	33,490.0	100.0
Нийт дүн	5	34,985.0	4	34,985.0	66.7

"Тохилог хараа" ААТҮГ нь өмнөх аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг давтан гаргасан байна. *Нягтлан бодогч Э.Болор-Эрдэнэ нь 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн Б/60 дугаар тушаалаар албан ажлаас чөлөөлөгдсөн/*

4.5. Дараагийн аудитаар анхаарах асуудал:

- Тус ААТҮГ-ын мах бэлтгэлийн төвийн үйл ажиллагаа нь алдагдалтай ажиллаж байгаа нь удирдлага, менежментийн үйл ажиллагаатай

холбоотой эсэх, бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийх эсэхийг гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах нь зүйтэй юм.

5. Аудитын илрүүлэлт :

5.1. Залруулга

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой **690,358.1** мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- ✓ Харилцагчдын нэр, тооцоог зөрүүтэй илэрхийлснээс авлага, өр төлбөр дансны дэлгэрэнгүй тайлангийн үлдэгдэл санхүүгийн байдлын тайлангийн үлдэгдлээс өр төлбөр 228,843.4 мянган төгрөгөөр, авлага 9,060.8 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй илэрхийлэгдсэн,
- ✓ Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 148 нэр төрлийн хөрөнгийн 10,11 дүгээр сарын элэгдлийг тооцоолоогүйгээс 416,122.3 мянган төгрөгөөр санхүүгийн үр дүнг бууруулсан,
- ✓ Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарзыг 1,156.3 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн,
- ✓ Үйл ажиллагааны орлогыг 35,175.3 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн гэх мэт.

Аудитаар нийт **9,885.1** мянган төгрөгийн 5 зөрчил² илэрснээс **9,885.1** мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 3 зөрчилд зөвлөмж өглөө.

5.2. Албан шаардлага

5.2.1. Мах нядалгааны төвийн шатахууны зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй, тооцоог тухай бүр бодоогүйгээс **1,173.9** мянган төгрөгийн шатахууны зарцуулалт анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр шатахууны зарцуулалтын гүйлгээг гүйцэтгэх, тооцоог тухай бүр хийж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.2. Нийгмийн даатгалын шимтгэл, татварын тайланд албан хаагчдын цалин, авлага, өр төлбөрийг **8,711.2** мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

“Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ. 20.2.5: “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тайланд 2 ажилтны **632.2** мянган төгрөгийн цалинг дутуу, 1 ажилтны **200.0** мянган төгрөгийн цалинг илүү болон ХХОАТ-ын тайланд 12 ажилтны **3,075.6** мянган төгрөгийн цалинг илүү,
- Татварын цахим системд цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан 13,382.7 мянган төгрөгийн албан татварын өр төлбөрийн үлдэгдэлтэй атал санхүүгийн тайланд 18,186.1 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнагдсан буюу өр төлбөрийг **4,803.4** мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.

Шийдвэрлэсэн нь: Татвар, нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлж, 2024 оны эхний хагас жилийн тайланд залруулга хийх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Нийт орлого, зардлын төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн жилийн дундуур бодит байдалд үндэслэн, тухайлбал түрээслэх хөрөнгийг бусдад шилжүүлсэн байхад орлогын төлөвлөгөөнд зохицуулалт хийгээгүй бөгөөд үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцож, тухайн жилийн нийт зардалд тусгаж төлөвлөөгүйгээс буюу бодит шалтгааны улмаас орлого зарлагын төлөвлөгөөний биелэлтийг хангаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь “*Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах*” гэсэн заалт болон Мандал сумын ИТХ-ын баталсан “Тохилог хараа” ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн орлого, зарлагын төлөвлөгөө” -г тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Бодит байдал, тооцоо судалгаанд үндэслэн нийт орлого, зардлыг үнэн зөв төлөвлөж, биелэлтийг ханган ажиллаж байх.

Мөнгөн кассын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Орлогын байцаагч Б.Алтантүрүүгийн хог үүсгэврийн төлбөрийн орлогыг тухай бүр хянаж, баталгаажуулаагүйгээс 1-3 дугаар сарын нийт 85 ширхэг баримт дутагдсан буюу анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан*”, 20 дугаар зүйлийн 20.2-т “*Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ. 20.2.5: “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Орлогын байцаагчийн бэлэн мөнгөний орлого, бичигдсэн нэхэмжлэх, төлөлт зэргийг тухай бүр хянаж баталгаажуулан, санхүүгийн тайланд үнэн зөв тусгах.

Газрын эзэмшил, бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Төрийн мэдээлэл солилцооны хур системд тухайн байгууллагын эзэмшилд 2 газар бүртгэлтэй байгаа боловч санхүүгийн тайланд 6 газар бүртгэгдэж, тайлагнагдсан бөгөөд тухайн газруудыг өөрийн эзэмшилд шилжүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*”: 14.4.2-д “*бүх хөрөнгө, ...*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Дээрх газруудын эзэмших эрхийн асуудлыг холбогдох байгууллагуудад уламжилж, шийдвэрлүүлэх, бүртгэл тайланд үнэн зөв тусгах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5³ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайлангийн өр төлбөрийн үлдэгдлийг дэлгэрэнгүй тайлангаас зөрүүтэй илэрхийлсэн	1	228,843.4			1	228,843.4	1	228,843.4				
Санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдлийг дэлгэрэнгүй тайлангаас зөрүүтэй илэрхийлсэн	1	9,060.8			1	9,060.8	1	9,060.8				
Үндсэн хөрөнгийн элэгдлийг дутуу байгуулсан	1	416,122.3	1	416,122.3			1	416,122.3				
Үндсэн хөрөнгө данснаас хасаны гарзыг илүү илэрхийлсэн	1	1,156.3			1	1,156.3	1	1,156.3				
Үйл ажиллагааны орлогыг дутуу илэрхийлсэн	1	35,175.3	1	35,175.3			1	35,175.3				
Дүн	5	690,358.1	2	451,297.6	3	239,060.5	5	690,358.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр шатахуун зарцуулсан	1	1,173.9			1	1,173.9						
Нийгмийн даатгалын болон татварын тайланд цалинг зөрүүтэй тайлагнасан	1	8,711.2			1	8,711.2						
Кассын орлогыг хянаж, баталгаажуулаагүй	1								1			
Орлого зарлагыг үнэн зөв төлөвлөөгүй	1								1			
Газрын эзэмших эрхийг өөрийн эзэмшилд шилжүүлээгүй	1								1			
Дүн	5	9,885.1			2	9,885.1	3					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Дүн		Тоо	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил	1						1	
Шилэн дансанд 6 мэдээллийг хоцроож, 24 мэдээллийг огт мэдээлээгүй								
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил	1	-						1
Худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй	1	-						1
Дүн	2							2
Нийт дүн								